



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

“Аялал жуулчлалын хөгжлийн төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион  
байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар,  
албан тушаалын жагсаалтыг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 21 (хорин нэг) байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 477 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн  
100 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**“Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын  
зохион байгуулалтын бүтцийн схем**



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн  
100 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**“Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит  
үйлдвэрийн газрын албан тушаалын жагсаалт, орон тоо**

№	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
<b>Нэг. Аялал жуулчлал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтэс</b>		
1	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан менежер	1
2	Судалгаа боомт хариуцсан мэргэжилтэн	1
3	Цахимжилт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1
4	Гадаад харилцааны мэргэжилтэн	1
5	Төслийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1
<b>Нийт</b>		<b>5</b>
<b>Хоёр. Маркетинг, сурталчилгааны хэлтэс</b>		
1	Маркетингийн менежер	1
2	Олон нийт, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1
3	Төсөл хөтөлбөр, эвент хариуцсан мэргэжилтэн	1
<b>Нийт</b>		<b>3</b>
<b>Гурав. Захирлын ажлын алба</b>		
1	Ерөнхий нягтлан бодогч	1
2	Хууль, эрх зүй, хүний нөөц хариуцсан менежер	1
3	Худалдан авалт хариуцсан менежер	1
<b>Нийт</b>		<b>3</b>
<b>Гэрээт ажилтан</b>		<b>9</b>
<b>НИЙТ ОРОН ТОО</b>		<b>21</b>